



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “ХӨХ ГАН” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөх Ган” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 30-ний өдрийн 14 цагт Чингэсийн өргөн чөлөө “Нэхээсгүй эдлэл” ХК-ийн хурлын байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
 - Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.
 - Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай
 - ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 17 дахь өдөр буюу 2020 оны 04 сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 16-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 03 сарын 31-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.

8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2020 оны 04 сарын 30-ний 14:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Мөнхбазар хурал зохион байгуулах комиссийн даргаар Д.Мөнхбазар гишүүнээр Н.Цэцэгдэмбэрэл, тооллогын комиссын даргаар С.Алтанцэцэг, гишүүнээр Л.Бямбадорж, Д.Шүрэнцэцэг, нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах ажлыг Гүйцэтгэх захирал Д.Мөнхбазарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.МӨНХТӨР/

“ХӨХ ГАН” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЧНЭЭ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 11

Улаанбаатар хот

ХУРЛЫН ТОВ

Хурал болсон хэлбэр	Эчнээ
Он сар өдөр	2020.03.11

ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Саналын хуудас хүргүүлсэн гишүүд	Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, Ц.Батбаяр, Ц.Батболд, Б.Алтансүвд, Х.Батхишиг, Д.Энхбат, Б.Мөнхтөр, Г.Энхболд
Саналын хуудас ирүүлсэн гишүүд	Ц.Батбаяр, Ц.Батболд, Х.Батхишиг, Д.Энхбат, Б.Мөнхтөр, Г.Энхболд, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, Б.Алтансүвд, Х.Батхишиг,
Хурлын ирц	88.89% буюу 8 гишүүн

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

- | |
|--|
| 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай |
|--|

Хэлэлцэх асуудлаар гарсан шийдвэрүүд:

Уг асуудлаар саналын хуудас ирүүлсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд 100% 8 гишүүн зөвшөөрснөөр уг асуудлыг хэлэлцэн баталсан.

Хурлаас гарсан шийдвэр:

1. “Хөх Ган” хувьцаат компанийн ХЭХ-ыг 2020 оны 04 сарын 30-ны 14:00 цагт Чингэсийн өргөн чөлөө “Нэхээсгүй эдлэл “ХК-ийн хурлын байран хуралдуулсугай.
2. ХЭХ-ийн зарыг СЗХ-ны Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хуралдуулсугай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

Цэцэгдэмбэрэл